

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/91-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2023 он	Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. Аудитын тайлан	18-20
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	21
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	22-23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БТСУХ	Биеийн тамир, спортын улсын хороо
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА У.БАТМӨНХ ТАНАА**

2023.02.16 № **СЭА-2023/91-НА-СТА-ТШЗ**

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 97.8 хувьтай тайлагнагдсан бөгөөд цалин хөлс, нэмэгдэл урамшлыг 0.5 хувиар, НДШ-ийг 0.8 хувиар, тогтмол зардлыг 1.8 хувиар тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, батлагдсан төсвийг 2.2 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 54.2 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол

зардал эзэлж байгаа бөгөөд цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 564,503.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 101,865.8 мянган төгрөг, урсгал засварт 58,008.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан



/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	161,844,189.00	172,052,915.25
35	БАРАА МАТЕРИАЛ	161,844,189.00	172,052,915.25
35100	Түүхий эд материал	73,498,724.00	75,512,836.00
35110	Тусгай зориулалттай материал	73,498,724.00	75,512,836.00
35400	Хангамжийн материал	88,345,465.00	96,540,079.25
35410	Бичиг хэргийн материал	4,226,960.00	3,330,840.00
35420	Аж ахуйн материал	51,877,322.50	58,910,785.75
35450	Барилгын засварын материал	293,500.00	0
35470	Бусад хангамжийн материал	31,947,682.50	34,298,453.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,501,523,424.73	8,231,527,867.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,501,523,424.73	8,231,527,867.07
39200	Биет хөрөнгө	8,336,309,674.73	8,067,042,867.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,682,946,127.00	8,682,946,127.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-773,870,481.08	-961,858,776.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,166,666.71	74,166,666.71
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,461,574.28	-50,322,685.48
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	295,966,844.82	275,154,247.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	-116,773,608.88	-113,002,673.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,097,010.00	57,883,293.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,311,616.52	-24,695,033.02
39214	Бусад үндсэн хөрөнгө	235,140,189.17	235,140,189.17
39215	Хуримтлагдсан элэгдэл	-84,589,882.21	-108,368,488.81
39300	Биет бус хөрөнгө	165,213,750.00	164,485,000.04
39301	Программ хангамж	3,535,000.00	3,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-381,250.00	-724,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	162,060,000.00	162,060,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,663,367,613.73	8,403,580,782.32
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,663,367,613.73	8,403,580,782.32
51	Засгийн газрын хувь оролцоо	8,663,367,613.73	8,403,580,782.32
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,086,045,198.00	1,086,045,198.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,086,045,198.00	1,086,045,198.00
51200	Хуримтлагдсан үр дүн	7,191,861,144.02	6,932,074,312.61
51210	Өмнөх үеийн үр дүн	6,059,927,107.29	7,191,861,144.02
51220	Тайлант үеийн үр дүн	1,131,934,036.73	-259,786,831.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	385,461,271.71	385,461,271.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,663,367,613.73	8,403,580,782.32

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан



Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,652,716,484.35	1,854,690,128.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,388,308,181.23	71,257,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,388,308,181.23	71,257,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,713,601.00	0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,713,601.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,368,194,580.23	65,257,900.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	400,000.00	6,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,264,408,303.12	1,783,432,228.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	587,545,100.00	607,419,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	587,545,100.00	607,419,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,977,200.00	114,229,568.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	79,223,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,977,200.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	35,005,968.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	663,886,003.12	1,061,783,060.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	663,886,003.12	1,061,783,060.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,520,782,447.62	2,107,244,308.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,520,782,447.62	2,107,244,308.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,458,946,957.82	2,068,906,668.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	436,413,816.52	502,793,905.68
210101	Үндсэн цалин	362,682,889.34	413,141,581.54
210102	Нэмэгдэл	73,730,927.18	43,717,616.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	32,061,140.00
210104	Урамшуулал	0	13,873,568.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,732,630.68	61,709,658.90
210201	Тэтгэврийн даатгал	40,583,065.66	42,305,167.31
210202	Тэтгэмжийн даатгал	4,118,578.47	4,984,441.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,291,681.35	3,954,153.40
210204	Ажилгүйдлийн даатгал	794,674.68	946,326.61
210205	Эрүүл мэндийн даатгал	7,944,630.52	9,519,570.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	649,969,763.12	896,451,846.00
210301	Гэрэл, цахилгаан	19,197,674.27	51,188,638.00
210302	Түлш, халаалт	608,374,613.85	794,809,346.00
210303	Цэвэр, бохир ус	22,397,475.00	50,453,862.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,283,789.50	27,206,853.75
210401	Бичиг хэрэг	2,198,550.00	3,403,570.00
210402	Тээвэр, шатахуун	5,845,100.00	1,932,675.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	917,901.00	1,210,980.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,136,800.00	343,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,648,438.50	12,205,860.75

210408	Бараа материал ахталсны зардал	5,537,000.00	8,110,768.00
2105	Нормативт зардал	0	28,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	28,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,628,790.00	59,342,850.00
210604	Урсгал засвар	22,628,790.00	59,342,850.00
2107	Томилолт, зочны зардал	921,000.00	873,300.00
210702	Дотоод албан томилолт	921,000.00	873,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,045,606.00	3,067,088.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,045,606.00	1,666,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0	187,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	623,500.00
210807	Газрын төлбөр	0	2,038.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	264,951,562.00	517,432,566.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,121,300.00	181,751,860.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	60,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	241,830,262.00	335,620,706.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,835,489.80	38,337,639.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,612,700.00	19,426,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,637,800.00	15,561,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,974,900.00	3,865,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,222,789.80	18,911,339.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	18,911,339.42
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	12,222,789.80	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,131,934,036.73	-252,554,180.32
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	7,232,651.09
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	7,232,651.09
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,131,934,036.73	-259,786,831.41

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан



Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,297,241,904.12	1,783,432,228.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,713,601.00	0
120	Нийтлэг татварын бус орлого	19,713,601.00	4317143998 0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,713,601.00	МНОА00065 9055436 0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,713,601.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,277,528,303.12	1,783,432,228.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	587,545,100.00	607,419,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	587,545,100.00	607,419,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,097,200.00	114,229,568.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	79,223,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,977,200.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,120,000.00	35,005,968.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	663,886,003.12	1,061,783,060.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	663,886,003.12	1,061,783,060.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,283,341,904.12	1,775,832,328.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,283,341,904.12	1,775,832,328.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,221,506,414.32	1,737,494,688.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	436,350,203.12	502,793,905.68
210101	Үндсэн цалин	362,619,275.94	413,141,581.54
210102	Нэмэгдэл	73,730,927.18	43,717,616.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	32,061,140.00
210104	Урамшуулал	0	13,873,568.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,732,631.08	61,709,658.90
210201	Тэтгэврийн даатгал	40,583,065.66	42,305,167.31
210202	Тэтгэмжийн даатгал	4,118,578.47	4,984,441.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,291,681.35	3,954,153.40
210204	Ажилгүйдлийн даатгал	794,674.68	946,326.61
210205	Эрүүл мэндийн даатгал	7,944,630.92	9,519,570.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	649,969,763.12	896,451,846.00
210301	Гэрэл, цахилгаан	19,033,704.27	51,188,638.00
210302	Түлш, халаалт	608,401,803.85	794,809,346.00
210303	Цэвэр, бохир ус	22,534,255.00	50,453,862.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,484,821.00	31,114,580.00
210401	Бичиг хэрэг	1,599,550.00	2,339,050.00
210402	Тээвэр, шатахуун	5,595,100.00	2,082,675.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	917,901.00	1,210,980.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,136,800.00	343,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,235,470.00	25,138,875.00
2105	Нормативт зардал	0	1,225,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	1,225,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,066,790.00	59,049,350.00
210604	Урсгал засвар	23,066,790.00	59,049,350.00

2107	Томилолт, зочны зардал	921,000.00	873,300.00
210702	Дотоод албан томилолт	921,000.00	873,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,045,606.00	3,187,088.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,045,606.00	1,666,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0	187,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	743,500.00
210807	Газрын төлбөр	0	2,038.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,935,600.00	181,089,360.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,935,600.00	181,029,360.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	60,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,835,489.80	38,337,639.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,612,700.00	19,426,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,637,800.00	15,561,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,974,900.00	3,865,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,222,789.80	18,911,339.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	18,911,339.42
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	12,222,789.80	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	13,900,000.00	7,599,900.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	13,900,000.00	7,599,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,900,000.00	7,599,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,900,000.00	7,599,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,900,000.00	7,599,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-13,900,000.00	-7,599,900.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,086,045,198.00	385,461,271.71	6,059,927,107.29	7,531,433,577.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,086,045,198.00	385,461,271.71	6,059,927,107.29	7,531,433,577.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,131,934,036.73	1,131,934,036.73
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,086,045,198.00	385,461,271.71	7,191,861,144.02	8,663,367,613.73
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,086,045,198.00	385,461,271.71	7,191,861,144.02	8,663,367,613.73
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,086,045,198.00	385,461,271.71	7,191,861,144.02	8,663,367,613.73
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,086,045,198.00	385,461,271.71	7,191,861,144.02	8,663,367,613.73
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	-259,786,831.41	-259,786,831.41
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,086,045,198.00	385,461,271.71	6,932,074,312.61	8,403,580,782.32


/төгрөгөөр/
 4317143098
 МЮА0065 9055436

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан



Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,690,412,500.00	1,652,832,488.58	37,580,011.42	97.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,690,412,500.00	1,652,832,488.58	37,580,011.42	97.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,673,386,200.00	1,635,806,188.58	37,580,011.42	97.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	505,152,500.00	502,793,905.68	2,358,594.32	99.53
210101	Үндсэн цалин	425,099,100.00	413,141,581.54	11,957,518.46	97.19
210102	Нэмэгдэл	40,377,200.00	43,717,616.14	-3,340,416.14	108.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,942,000.00	32,061,140.00	-7,119,140.00	128.54
210104	Урамшуулал	14,734,200.00	13,873,568.00	860,632.00	94.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,185,300.00	61,709,658.90	475,641.10	99.24
210201	Тэтгэврийн даатгал	42,377,900.00	42,305,167.31	72,732.69	99.83
210202	Тэтгэмжийн даатгал	4,992,800.00	4,984,441.54	8,358.46	99.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,967,300.00	3,954,153.40	13,146.60	99.67
210204	Ажилгүйдлийн даатгал	982,800.00	946,326.61	36,473.39	96.29
210205	Эрүүл мэндийн даатгал	9,864,500.00	9,519,570.04	344,929.96	96.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	912,670,300.00	896,451,846.00	16,218,454.00	98.22
210301	Гэрэл, цахилгаан	68,283,300.00	51,188,638.00	17,094,662.00	74.97
210302	Түлш, халаалт	812,217,700.00	794,809,346.00	17,408,354.00	97.86
210303	Цэвэр, бохир ус	32,169,300.00	50,453,862.00	18,284,562.00	156.84
2104	Хангамж, бараа материалын зардал	11,395,900.00	11,395,580.00	320.00	100.00
210401	Бичиг хэрэг	1,372,800.00	1,770,950.00	-398,150.00	129.00
210402	Тээвэр, шатахуун	2,860,000.00	1,882,675.00	977,325.00	65.83
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,464,300.00	1,210,980.00	253,320.00	82.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	572,000.00	343,000.00	229,000.00	59.97
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,126,800.00	6,187,975.00	-1,061,175.00	120.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,000,000.00	58,008,650.00	4,991,350.00	92.08
210604	Урсгал засвар	63,000,000.00	58,008,650.00	4,991,350.00	92.08
2107	Томилолт, зочны зардал	1,916,000.00	873,300.00	1,042,700.00	45.58
210702	Дотоод албан томилолт	1,916,000.00	873,300.00	1,042,700.00	45.58
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,338,600.00	2,707,488.00	631,112.00	81.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,430,000.00	1,430,000.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	-	500,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00	0.00	100.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	187,500.00	187,450.00	50.00	99.97
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	500,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	133,100.00	2,038.00	131,062.00	1.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,727,600.00	101,865,760.00	11,861,840.00	89.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	112,925,600.00	101,805,760.00	11,119,840.00	90.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	802,000.00	60,000.00	742,000.00	7.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,026,300.00	17,026,300.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,026,300.00	17,026,300.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,561,300.00	15,561,300.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,465,000.00	1,465,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,690,412,500.00	1,669,202,660.00	21,209,840.00	98.75
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	607,419,600.00	607,419,600.00	0.00	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	607,419,600.00	607,419,600.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,082,992,900.00	1,061,783,060.00	21,209,840.00	98.04
320001	Орон нутгийн төсвөөс	1,082,992,900.00	1,061,783,060.00	21,209,840.00	98.04
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	115.00	115.00	0.00	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	57.00	57.00	0.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	27.00	27.00	0.00	-
620003	Үйлчлэх ажилтан	29.00	29.00	0.00	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	57.00	57.00	0.00	-
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1.00	1.00	0.00	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	56.00	56.00	0.00	-



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан



Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		114,229,568.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		114,229,568.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		109,288,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал		19,719,000.00
210401	Бичиг хэрэг		568,100.00
210402	Тээвэр, шатахуун		200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		18,950,900.00
2105	Нормативт зардал		1,225,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,225,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		8,640,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		7,599,900.00
210602	Тавилга		1,040,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		479,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		236,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		243,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		79,223,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		79,223,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		4,941,168.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		2,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,400,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		2,541,168.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		2,541,168.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		114,229,568.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		114,229,568.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		79,223,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		35,005,968.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газар /цаашид БТСГ гэх/ нь "Биеийн тамир спортыг орчин үеийн шинжлэх ухааны ололт, үндэсний уламжлалт ёс заншилд тулгуурлан хөгжүүлж, хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэн, бие бялдарын хүмүүжил олгон чийрэгжүүлж, эрүүл аж төрөх, хөдөлмөрлөх зорилгыг эрхэм болгон мэргэжлийн ур чадвартай өндөр зэрэгтэй тамирчид бэлтгэн гаргах таатай нөхцөлийг бүрдүүлэх" гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Биеийн тамир, спортын тухай хуульд 2022 оны 06 дугаар сарын 28, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

БТСГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд БТСУХ-ны "Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс"-ээс хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд дотоод хяналт шалгалт, аудит хийгдээгүй байна.


Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

БТСГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.



Аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан төсөвт байгууллагуудад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

БТСГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 259,786.8 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	161,844.2	172,052.9	10,208.7
Үндсэн хөрөнгө	8,501,523.4	8,231,527.9	(269,995.5)
Нийт хөрөнгө	8,663,367.6	8,403,580.8	(259,786.8)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,663,367.6	8,403,580.8	(259,786.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,663,367.6	8,403,580.8	(259,786.8)

Бараа материалын дансны үлдэгдэл 172,052.9 мянган төгрөг болж 10,208.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 126,224.0 мянган төгрөгийн материал худалдан авч, аймгийн ОНХС-аас 6,000.0 мянган төгрөгийн зүлэгний үр шилжүүлэн авсан, 113,904.5 мянган төгрөгийн материалыг зарцуулсан болон 8,110.8 мянган төгрөгийн материалыг акталж, устгаснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 9,490,500.5 мянган төгрөг болж 23,411.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 7,599.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, аймгийн ИТХ-ын 2022 оны 90 дүгээр тогтоолын дагуу 31,011.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, программ хангамж акталж, данс бүртгэлээс хассан, ОНӨГ-ын даргын 2022 оны 344 дүгээр тушаалын дагуу ашиглалтын хугацаа дууссан 65,257.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, программ хангамжийн ашиглах хугацааг сунгаснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,403,580.8 мянган төгрөг болж 259,786.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны нийт үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,620,477.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 165,270.8 мянган төгрөгөөр бууруулж /Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 297,944.5 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 47,841.2 мянган төгрөгөөр тус тус бууруулж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 115,543.9 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 48,240.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 29,035.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна./ 1,455,206.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 235,206.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн /Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 246,322.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 49,570.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, эд хогшил, урсгал засварын зардлыг 60,000.0 мянган төгрөгөөр бууруулсан нь голлон нөлөөлсөн./ зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,690,412.5 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 607,419.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,082,992.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,652,832.5 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 5,651.3 мянган төгрөгөөр, биеийн тамирын уралдаан, тэмцээний зардлыг 1,830.0 мянган төгрөгөөр, нийтийн биеийн тамирын зардлыг 8,888.8 мянган төгрөгөөр, төрийн өмчийн барилгын тогтмол

зардлыг 21,209.8 мянган төгрөгөөр, нийтлэг үйлчилгээний зардлыг 0.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	367,269.4	361,618.1	5,651.3	98.5
2	Туслах үйл ажиллагааны зардал	110,599.3	110,599.3	-	100.0
3	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	65,184.0	63,354.0	1,830.0	97.2
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	17,026.3	17,026.3	-	100.0
5	Нийтийн биеийн тамир	47,340.6	38,451.8	8,888.8	81.2
6	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	975,670.3	954,460.5	21,209.8	97.8
7	Нийтлэг үйлчилгээ	107,322.6	107,322.5	0.1	100.0
	Дүн	1,690,412.5	1,652,832.5	37,580.0	97.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130035401 тоот дансанд нийт 114,229.6 мянган төгрөгийн дараах санхүүжилтийг төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулан, үлдэгдэл 2,541.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн ЗДНХ-өөс 61,408.0 мянган төгрөг, мөрийн хөтөлбөрийн зардлаас 15,925.6 мянган төгрөг, баяр наадмын зардлаас 1,890.0 мянган төгрөг зэрэг нийт 79,223.6 мянган төгрөг,
- Өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 35,006.0 мянган төгрөг.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу БТСГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

БТСГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,520,782.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 15,207.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор БТСУХ-ны даргын 2022 оны 1/807 дугаар “Төсвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” албан бичгийг хэрэгжүүлж, төсвийг зохистой удирдаж, авлага, өглөг үүсгэлгүй ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд БТСГ-ын мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн боловч 20,921.1 мянган төгрөгийн 2 /цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ/ мэдээллийг огт мэдээлээгүй бөгөөд хэрэгжилт 99.4 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 38,233.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй 1 зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	38,233.4			
Нийт дүн	1	38,233.4			

Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”,

4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.



4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хэдийгээр үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах болон тамирчдыг тэмцээн уралдаанд оролцоход зориулж нийт 206,876.5 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж, замын зардалд 9,676.5 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 34,767.4 мянган төгрөг, буудлын зардалд 29,565.0 мянган төгрөг, шатахууны зардалд 9,613.7 мянган төгрөг, шүүгчийн хөлсөнд 5,920.0 мянган төгрөг, шагналын зардалд 65,135.0 мянган төгрөг, өргөмжлөл, медаль, цом, анонс хэвлүүлэх зардалд 31,866.5 мянган төгрөг зэрэг нийт 186,544.1 мянган төгрөгийг зарцуулсан боловч тэмцээний зардлыг дасгалжуулагч, багш нарын харилцах дансаар дамжуулан зарцуулж байгаа нь анхан шатны баримтын бүрдэл дутуу, төлбөрийн цахим баримтгүй худалдан авалтууд хийх эрсдэлийг дагуулж байна.

Иймд уралдаан, тэмцээний зардлаар гарч буй холбогдох ажил гүйлгээг нэхэмжлэгч байгууллагын анхан шатны баримтыг үндэслэн, харилцах дансаар гүйцэтгэж байх шаардлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	Тоо	Дүн	/мянган төгрөгөөр/
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Мэдээллийг шилэн дансанд огт мэдээлээгүй.	1	20,921.1						1	20,921.1	
Дүн	1	20,921.1						1	20,921.1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн	1	20,921.1						1	20,921.1	